



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар

111


Улаанбаатар хот

Улаанбаатар хотын аварга шалгаруулах “Ширээний теннис”-ний тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах “Ширээний теннис”-ний тэмцээнийг 2018 оны 03 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд “Оч” клубт зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 3.274.000 /гурван сая хоёр зуун далан дөрвөн мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг /-т үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500048


Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн
А.А. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын ширээний теннисний
аварга шалгаруулах тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 36 x 20.000 төг = 720.000 төг 36 x 15.000 төг = 540.000 төг 36 x 10.000 төг = 360.000 төг	1.620.000
2.	Шүүгчдийн ажлын зардал: 16 хүн x 2 өдөр x 20.000 төг	640.000
3.	Өргөмжлөл	100.000
4.	Медаль:	864.000
5.	Анонс, цом,	50.000
Нийт дүн		3.274.000

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2018 оны... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Улаанбаатар хотын ширээний теннис аварга шалгаруулах тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | С.Галбадрах |
| 2. Шүүгч | Р.Мөнхсайхан |
| 3. Шүүгч | Э.Цэцгээ |
| 4. Шүүгч | Ц.Мөнхдалай |
| 5. Шүүгч | Г.Гэрэлсайхан |
| 6. Шүүгч | А.Анужин |
| 7. Шүүгч | Б.Баясгалан |
| 8. Шүүгч | А.Мөнх-Эрдэнэ |
| 9. Шүүгч | С.Отгонбаатар |
| 10. Шүүгч | Б.Батсайхан |
| 11. Шүүгч | М.Цогзолмаа |
| 12. Шүүгч | У.Мягмарсүрэн |
| 13. Шүүгч | А.Амгалан |
| 14. Шүүгч | У.Нарантуяа |
| 15. Шүүгч | С.Удвал |
| 16. Шүүгч | А.Энхмаа |